

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/30/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТББ	Төрийн бус байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
3.1.2	Эрсдэл:.....	12
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	13
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	16
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	18
4.4	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ
С.ЦАГААНХҮҮ ТАНАА

2019.03.15 № 06/467
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдалд, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын үр дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын захирал С.Цагаанхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль тогтоомжтой хобоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 06-аас 2019 оны 03 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өлзийт экаунт аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа 2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/64 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь “Бид харилцаа холбоо, мэдээллийн технологийн шинэ дэвшилтэт технологийг ашиглан хэрэглэгчийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг нь хангасан нийлмэл, орон зайнаас үл хамаарсан Радио телевизийн өргөн нэвтрүүлгийн үндэсний тоон технологийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Төрийн Өмчийн хорооны 2015 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 230 дугаар тогтоолоор “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Олон нийтийн радио, телевизийн үндсэн ба нэмэгдэл сувгийн нэвтрүүлгийг улс орон даяар дамжуулан түгээх,

- Гадаад үзэгч, сонсогчдод зориулсан олон нийтийн болон бусад радио, телевизийн нэвтрүүлгийг өөрийн үндсэн сүлжээгээр дамжуулан түгээх,

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Харилцаа холбооны тухай хууль
- Радио долгионы тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллага нь 2018 онд техник зохион байгуулалт, захиргаа удирдлага, санхүү хангамж үйлчилгээ, маркетинг төлөвлөгөө, хяналт шинжилгээний чиглэлээр дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэсэн байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Энэ нь төлөвлөлтийн шатанд сонгосон материаллаг суурийг өөрчлөх ноцтой шалтгаан ажиглагдаагүй болно.

Төлөвлөлтийн үе шатанд “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 3,457.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 69.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсныг гүйцэтгэлийн үе шатанд хэвээр үлдээсэн.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг төлөвлөлтийн шатанд 2 хувиар тооцоход эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 28 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Зардлын ангилал зөрүүлэн бүртгэсэн 28.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан бүртгэсэн болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	6.0	
2	Албан шаардлага өгсөн	2	33.8	
	Дүн	3	39.8	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар

Тайлант онд 16.2 сая төгрөгийн компьютер техник хэрэгсэл болон 12.6 сая төгрөгийн засвар үйлчилгээ нийт 28.7 сая төгрөгийн бараа, үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд худалдан авсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68

дугаар тогтоолын хавсралтын 2 дахь заалтыг зөрчсөн ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

Асуудал 2: Зардлын данстай холбоотой

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн Б/110 тоот тушаалаар Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Ш.Батдэлгэрийг үүрэгт ажлаас нь чөлөөлж 3 сарын дундаж хөлстэй тэнцэх хэмжээний 5.0 сая төгрөгний тэтгэмжийг шүүхийн шийдвэргүй, байгууллагын төсвөөс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дүгээрт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах”, “Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 “Иргэн хуулийн хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” заалтуудыг тус тус зөрчсөн нь үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ -ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсвөөс 4,429.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 932.2 сая төгрөг, урьд оны санхүүжилтийн дутуу 1,925.0 сая төгрөг нийт 7,287.2 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсвөөс урьд оны санхүүжилтийн дутуу орж ирээгүй ба харин үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 16.5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Тайлант онд 7,287.2 сая төгрөгийн нийт зардлын төсөв батлагдсанаас санхүүжилтийн дутуугаас шалтгаалан 5,402.9 сая төгрөгийг зарцуулсан. Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн өр 33.2 сая төгрөгийн төлөлт болон шатахууны үнийн

өсөлтөөс шалтгаалан 2.4 сая төгрөгийн төсвийг хэтрүүлж зарцуулсан байна. Төсвийн дутуугаас шалтгаалан байр ашиглалттай холбоотой зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг төлж барагдуулалгүй өглөгтэй тайлагнагджээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ нь 5 сая төгрөгөөс дээш 254 ширхэг 5,429.4 сая төгрөгийн зарлагын гүйлгээ, 5,937.8 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 30 ширхэг 689.0 сая төгрөгийн худалдан авалтын гүйлгээ болон төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой 233 ширхэг мэдээ мэдээллийг байршуулсан бөгөөд 2018 оны 05 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 138.0 сая төгрөгийн алдаанд 3 зөвлөмж хүргүүлснээс биелэлт нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Аж ахуйн нэгж байгууллагаас бараа ажил үйлчилгээ худалдан авсан Ибаримтыг бүрдүүлж ажиллаагүй.

3.1 Зардлын данстай холбоотой асуудал:

3.1.1 Илрүүлэлт:

“Мэдээлэлжсэн ухаалаг нийгэм” ТББ-д 6.0 сая төгрөгийн сургалт, арга хэмжээний төлбөр төлсөн боловч ажил үйлчилгээ худалдан авсан баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалын 1 дэх хавсралтад “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах “ гэж заасныг зөрчсөн ба үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Холбогдох татварын хууль зөрчигдөх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж байгууллага, хувь хүнээс цахим төлбөрийн баримтыг анхан шатны баримт болгон хавсарган хэвших.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,339,559,928.75</u>	<u>2,339,142,653.83</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,314,869.95	39,302,554.13
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5,655,380.57	6,687,272.57
31110	Төгрөг	5,655,380.57	6,687,272.57
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	57,659,489.38	32,615,281.56
3121	Төгрөг	57,482,824.38	32,436,986.20
31211	Төрийн сангийн харилцах	57,482,824.38	32,436,986.20
3122	Гадаад валют	176,665.00	178,295.36
31221	Төрийн сангийн харилцах	176,665.00	178,295.36
33	АВЛАГА	365,086,309.00	156,137,418.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,200,323.00	1,043,286.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	308,031,160.00	103,387,235.00
335	Бусад авлага	54,854,826.00	51,706,897.57
3351	Байгууллагаас авах авлага	5,081,397.00	3,355,094.57
3352	Хувь хүмүүсээс авах авлага	49,773,429.00	48,351,803.00
34	УРЬДЧИЛГАА	190,568,503.00	27,966,604.00
3471	Урьдчилгаа тооцоо	190,568,503.00	27,966,604.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	13,378,000.00	3,500,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	174,059,285.00	20,000,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,981,218.00	2,840,000.00
34714	Томилолтын урьдчилгаа	1,150,000.00	1,626,604.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,720,590,246.80	2,115,736,077.13
354	Хангамжийн материал	1,720,590,246.80	2,115,736,077.13
35410	Бичиг хэргийн материал	4,070,456.64	4,767,826.34
35420	Аж ахуйн материал	22,287,824.61	26,896,799.38
35430	Сэлбэг хэрэгсэл	1,524,692,566.49	1,922,421,164.16
35440	Түлш, шатах тослох материал	3,238,926.06	8,510,036.25
35460	Хүнсний материал		125,336.00
35470	Бусад хангамжийн материал	166,300,473.00	153,014,915.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,767,790,832.13</u>	<u>84,161,084,393.16</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,767,790,832.13	84,161,084,393.16
392	Биет хөрөнгө	14,730,921,040.41	16,984,713,576.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,001,299,345.04	5,239,722,915.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,051,361,193.80)	(133,162,577.57)

**“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

39203	Авто-тээврийн хэрэгсэл	999,352,799.00	1,047,826,973.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	(724,023,454.95)	(820,320,065.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,013,704,204.62	31,161,713,990.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,605,991,122.69)	(19,612,421,624.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	257,240,107.90	274,701,970.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(162,901,144.78)	(179,641,042.91)
39209	Зам, гүүрийн байгууламж		18,542,250.00
39210	Хуримтлагдсан элэгдэл		(18,542,250.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,322,976.00	36,575,926.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,721,475.93)	(30,282,890.06)
393	Биет бус хөрөнгө	36,869,791.72	67,176,370,816.55
39301	Програм хангамж	113,950,480.00	122,820,480.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(77,080,688.28)	(97,215,063.45)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,770,000.00	67,154,535,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(3,770,000.00)	(3,770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>17,107,350,760.88</u>	<u>86,500,227,046.99</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>275,154,751.88</u>	<u>122,153,192.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	275,154,751.88	122,153,192.00
413	Өглөг	275,154,751.88	122,153,192.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	88,976,961.88	9,488,819.00
4136	Бусад өглөг	186,177,790.00	112,664,373.00
41361	Байгууллагад төлөх өглөг	179,923,200.00	106,424,096.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,254,590.00	6,240,277.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>16,832,196,009.00</u>	<u>86,378,073,854.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	16,832,196,009.00	86,378,073,854.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	13,058,417,039.87	80,210,908,069.87
51101	Өмч: - төрийн	13,058,417,039.87	80,210,908,069.87
512	Хуримтлагдсан үр дүн	2,339,869,338.68	1,571,931,092.30
51210	Өмнөх үеийн үр дүн	2,339,869,338.68	2,314,273,211.73
51220	Тайлант үеийн үр дүн		(742,342,119.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,433,909,630.45	4,595,234,692.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>17,107,350,760.88</u>	<u>86,500,227,046.99</u>

4.2 Аудит хийсэн Санхүү үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,657,104,800.58	7,076,937,065.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,657,104,800.58	902,716,619.88
120	Нийтлэг татварын бус орлого	1,715,797,800.58	902,716,619.88
120002	Хүүгийн орлого	6,510,949.15	8,211,173.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,649,786,416.43	828,755,246.69
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,276,919,980.45	388,271,849.64
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	372,866,435.98	440,483,397.05
120009	Бусад орлого	59,500,435.00	65,750,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,941,307,000.00	6,174,220,446.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,941,307,000.00	6,174,220,446.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,931,102,000.00	4,429,952,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	10,205,000.00	1,744,268,446.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,619,219,812.89	7,663,570,434.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,619,219,812.89	7,663,570,434.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,563,102,639.89	7,569,928,263.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,271,643,194.12	2,276,066,619.00
210101	Үндсэн цалин	2,271,643,194.12	2,276,066,619.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	250,167,709.26	278,996,808.53
210201	Тэтгэврийн даатгал	206,332,136.38	187,538,157.59
210202	Тэтгэмжийн даатгал		22,752,542.63
210203	ҮОМШӨ-ний даатгал		18,537,602.79
210204	Ажилгүйдлийн даатгал		4,545,651.56
210205	Эрүүл мэндийн даатгал	43,835,572.88	45,622,853.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,145,895,160.85	966,305,029.71
210301	Гэрэл, цахилгаан	1,062,677,319.85	878,841,921.71
210302	Түлш, халаалт	70,050,669.50	75,897,050.00
210303	Цэвэр, бохир ус	11,400,771.50	11,035,058.00
210304	Байрны түрээс	1,766,400.00	531,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	155,930,825.02	171,220,996.47
210401	Бичиг хэрэг	14,914,105.69	14,299,056.30
210402	Тээвэр, шатахуун	71,747,139.97	79,536,871.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,231,723.22	31,415,234.13
210404	Ном, хэвлэл	568,180.00	1,389,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	813,500.00	820,000.00

**“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,729,085.60	21,845,611.01
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,927,090.54	21,914,823.22
2105	Нормативт зардал	8,296,444.00	32,446,030.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,296,444.00	32,446,030.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	190,042,163.40	268,470,143.78
210604	Урсгал засвар	190,042,163.40	268,470,143.78
2107	Томилолт, зочны зардал	106,507,293.18	133,065,528.02
210701	Гадаад албан томилолт	48,981,758.18	67,898,648.02
210702	Дотоод албан томилолт	57,525,535.00	65,166,880.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	353,840,006.47	391,761,520.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,619,839.12	162,433,757.72
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		9,240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	49,945,816.00	21,537,444.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,279,300.00	2,065,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	90,419,551.75	140,927,927.00
210807	Газрын төлбөр	68,590,363.00	55,085,115.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	985,136.60	472,277.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,080,779,843.59	3,051,595,587.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,928,987.00	77,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,265,000.00	12,861,554.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,070,585,856.59	3,038,657,033.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,117,173.00	93,642,171.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,117,173.00	93,642,171.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,117,173.00	93,642,171.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,962,115,012.31)	(586,633,368.65)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	526,613.08
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		526,613.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,968,429.48	156,235,363.86
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		49,283,234.59
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	6,968,429.48	305,298.76
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		106,646,830.51
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,968,429.48)	(155,708,750.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,969,083,441.79)	(742,342,119.43)

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,249,824,296.38	5,378,703,872.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,318,529,137.38	948,751,872.77
120	Нийтлэг татварын бус орлого	1,318,529,137.38	948,751,872.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,253,501,126.94	883,001,672.77
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	867,279,225.13	452,568,931.64
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	386,221,901.81	430,432,741.13
120008	Бусад орлого	65,028,010.44	65,750,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,931,295,159.00	4,429,952,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,931,102,000.00	4,429,952,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,931,102,000.00	4,429,952,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	193,159.00	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	193,159.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,354,325,713.61	5,109,287,925.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,354,325,713.61	5,109,287,925.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,299,887,340.61	5,040,411,052.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,221,926,642.21	2,321,137,196.51
210101	Үндсэн цалин	2,221,926,642.21	2,321,137,196.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	241,833,211.37	315,226,854.63
210201	Тэтгэврийн даатгал	154,875,091.76	211,815,488.58
210202	Тэтгэмжийн даатгал	17,839,213.79	25,753,719.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,087,149.35	21,013,096.09
210204	Ажилгүйдлийн даатгал	5,067,257.23	5,162,757.20
210205	Эрүүл мэндийн даатгал	42,964,499.24	51,481,792.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,031,929,766.85	989,161,224.71
210301	Гэрэл, цахилгаан	966,683,045.85	903,267,336.71
210302	Түлш, халаалт	52,156,549.50	74,331,330.00
210303	Цэвэр, бохир ус	11,323,771.50	11,031,558.00
210304	Байрны түрээс	1,766,400.00	531,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	191,093,460.25	165,546,334.13
210401	Бичиг хэрэг	16,349,280.00	13,904,577.00
210402	Тээвэр, шатахуун	71,900,417.03	79,911,692.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,313,028.22	32,289,029.13
210404	Ном, хэвлэл	568,180.00	1,476,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	810,000.00	765,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	62,028,207.00	23,125,384.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	11,124,348.00	14,074,452.00
2105	Нормативт зардал	10,242,020.00	47,264,333.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,242,020.00	47,264,333.00

**“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	203,899,401.00	668,278,546.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,004,350.00	
210602	Тавилга	640,000.00	
210604	Урсгал засвар	184,255,051.00	668,278,546.00
2107	Томилолт, зочны зардал	106,923,782.98	133,082,478.02
210701	Гадаад албан томилолт	44,775,000.00	67,898,648.02
210702	Дотоод албан томилолт	62,148,782.98	65,183,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	283,378,655.95	387,898,085.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,291,394.01	142,184,153.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		9,240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	49,945,812.99	21,537,444.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,279,300.00	2,065,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	268,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	79,345,335.35	121,214,630.40
210807	Газрын төлбөр	26,263,677.00	91,184,581.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	985,136.60	472,277.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,660,400.00	12,816,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,395,400.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,265,000.00	12,816,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,438,373.00	68,876,873.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,438,373.00	68,876,873.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	54,438,373.00	68,876,873.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(104,501,417.23)	269,415,946.86
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	203,681,668.00	293,650,073.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	203,681,668.00	293,650,073.00
2200	Дотоод эх үүсвэрээр	203,681,668.00	293,650,073.00
220001	Барилга байгууламж	65,900,000.00	
221001	Их засвар	124,657,468.00	20,000,000.00
223001	Бусад хөрөнгө	13,124,200.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		273,650,073.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(203,681,668.00)	(293,650,073.00)
14	Бусад эх үүсвэр	-	221,810.32
145001	Гадаад валютын ханшийн зөрүү		221,810.32
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	6,968,429.49	
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	6,968,429.49	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,968,429.49)	221,810.32
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(315,151,514.72)	(24,012,315.82)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	378,466,384.67	63,314,869.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,314,869.95	39,302,554.13

4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,058,417,039.87	1,433,909,630.45	5,308,952,780.47	19,801,279,450.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,058,417,039.87	1,433,909,630.45	5,308,952,780.47	19,801,279,450.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			(2,969,083,441.79)	(2,969,083,441.79)
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,058,417,039.87	1,433,909,630.45	2,339,869,338.68	16,832,196,009.00
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,058,417,039.87	1,433,909,630.45	2,339,869,338.68	16,832,196,009.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(25,596,126.95)	(25,596,126.95)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,058,417,039.87	1,433,909,630.45	2,314,273,211.73	16,806,599,882.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	3,161,325,062.37	-	3,161,325,062.37
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	67,152,491,030.00	-	-	67,152,491,030.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн			(742,342,119.43)	(742,342,119.43)
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	80,210,908,069.87	4,595,234,692.82	1,571,931,092.30	86,378,073,854.99

4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,287,207,128.00	5,402,937,998.91	1,884,269,129.09	74.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,287,207,128.00	5,402,937,998.91	1,884,269,129.09	74.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,237,547,128.00	5,040,411,052.91	1,197,136,075.09	80.8%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,350,441,900.00	2,321,137,196.51	29,304,703.49	98.8%
210101	Үндсэн цалин	2,350,441,900.00	2,321,137,196.51	29,304,703.49	98.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	282,053,028.00	315,226,854.63	(33,173,826.63)	111.8%
210201	Тэтгэврийн даатгал	188,035,352.00	211,815,488.58	(23,780,136.58)	112.6%
210202	Тэтгэмжийн даатгал	18,803,535.20	25,753,719.81	(6,950,184.61)	137.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,504,419.00	21,013,096.09	2,491,322.91	89.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,700,883.80	5,162,757.20	(461,873.40)	109.8%
210205	Эрүүл мэндийн даатгал	47,008,838.00	51,481,792.95	(4,472,954.95)	109.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,663,831,900.00	989,161,224.71	674,670,675.29	59.5%
210301	Гэрэл, цахилгаан	1,556,160,000.00	903,267,336.71	652,892,663.29	58.0%
210302	Түлш, халаалт	91,585,200.00	74,331,330.00	17,253,870.00	81.2%
210303	Цэвэр, бохир ус	14,646,700.00	11,031,558.00	3,615,142.00	75.3%
210304	Байр түрээс	1,440,000.00	531,000.00	909,000.00	36.9%
2104	Хангамж, бараа материалын зардал	206,384,800.00	165,546,334.13	40,838,465.87	80.2%
210401	Бичиг хэрэг	18,463,600.00	13,904,577.00	4,559,023.00	75.3%
210402	Тээвэр, шатахуун	77,378,000.00	79,911,692.00	(2,533,692.00)	103.3%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,094,400.00	32,289,029.13	4,805,370.87	87.0%
210404	Ном хэвлэл	2,518,800.00	1,476,200.00	1,042,600.00	58.6%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,220,000.00	765,000.00	455,000.00	62.7%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,400,000.00	23,125,384.00	27,274,616.00	45.9%
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	19,310,000.00	14,074,452.00	5,235,548.00	72.9%
2105	Нормативт зардал	58,132,000.00	47,264,333.00	10,867,667.00	81.3%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	58,132,000.00	47,264,333.00	10,867,667.00	81.3%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	755,000,000.00	668,278,546.00	86,721,454.00	88.5%
210604	Урсгал засвар	755,000,000.00	668,278,546.00	86,721,454.00	88.5%

**“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2107	Томилолт, зочны зардал	168,971,200.00	133,082,478.02	35,888,721.98	78.8%
210701	Гадаад албан томилолт	93,950,000.00	67,898,648.02	26,051,351.98	72.3%
210702	Дотоод албан томилолт	75,021,200.00	65,183,830.00	9,837,370.00	86.9%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,002,300.00	387,898,085.91	347,104,214.09	52.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	426,879,800.00	142,184,153.50	284,695,646.50	33.3%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,240,000.00	9,240,000.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	33,287,300.00	21,537,444.00	11,749,856.00	64.7%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,257,400.00	2,065,000.00	192,400.00	91.5%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо			-	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	153,216,900.00	121,214,630.40	32,002,269.60	0.0%
210807	Газрын төлбөр	103,620,900.00	91,184,581.00	12,436,319.00	88.0%
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		472,277.01	(472,277.01)	
210810	Олон улсын татвар	6,500,000.00		6,500,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,730,000.00	12,816,000.00	4,914,000.00	72.3%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,730,000.00	12,816,000.00	4,914,000.00	72.3%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,049,660,000.00	362,526,946.00	695,566,800.00	34.5%
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,660,000.00	68,876,873.00	64,216,873.00	55.3%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	60,000,000.00		60,000,000.00	0.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,660,000.00	68,876,873.00	4,216,873.00	106.5%
	Хөрөнгийн санхүүжилт	925,000,000.00	293,650,073.00	631,349,927.00	31.7%
222001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	847,000,000.00	273,650,073.00	573,349,927.00	32.3%
223001	Бусад зардал	78,000,000.00	20,000,000.00	58,000,000.00	25.6%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,287,207,000.00	5,378,703,872.77	1,908,503,127.23	73.8%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,354,998,400.00	4,429,952,000.00	1,925,046,400.00	69.7%
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,429,952,400.00	4,429,952,000.00	400.00	100.0%
	Өмнөх оны санхүүжилтийн дутуу	1,925,046,000.00		1,925,046,000.00	0.0%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	932,208,600.00	948,751,872.77	(16,543,272.77)	101.8%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,888,000.00	452,568,931.64	(1,680,931.64)	100.4%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	481,320,600.00	496,182,941.13	(14,862,341.13)	103.1%

**“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		63,314,869.95	(63,314,869.95)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		39,302,554.13	(39,302,554.13)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	233.00	232.00	1.00	99.6%
620001	Удирдах ажилтан	27.00	28.00	(1.00)	103.7%
620002	Гүйцэтгэх ажилтан	151.00	149.00	2.00	98.7%
620003	Үйлчлэх ажилтан	55.00	55.00	-	100.0%

“Радио телевизийн үндэсний сүлжээ” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажлын баримтын нэр:	Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл
Ажлын баримтын дугаар:	B501
Аудитын код:	САГ-2019/30/СТА-ТӨҮГ
Аудитын нэр:	Радио телевизийн үндэсний сүлжээний газар УҮГ

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийлгэсэн байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Гаргасан шийдэл	
									Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	2	Мэдээлэлжсэн ухаалаг нийгэм ТББ-д 6,000.0 мянган төгрөгийн сургалт, арга хэмжээний төлбөр төлсөн боловч Е баримт аваагүй.	6.0	Зөвлөмж өгөх			Зөвлөмж өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Дарга, Ерөнхий нягтлан бодогч
2	Зардлын данстай холбоотой асуудал	3	Захирлын тушаалаар Ш.Батдэлгэр 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 5,000.0мянган төгрөг олгосон.	5.0	Албан шаардлага өгөх			Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	С.Цагаанхүү, Б.Батмөнх
3	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	3	Тайлант онд 16,175.0 мянган төгрөгийн компьютер, Буянт оюу ХХК-аас 12,589.6 мянган төгрөг үйлчилгээ нийт 28,764.6 мянган төгрөг ийг харьцуулалтын үнийн арга хэрэглэлгүй шууд худалдан авсан.	28.8	Албан шаардлага өгөх			Албан шаардлага өгөх	Дарга	С.Цагаанхүү

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the summary.